



## НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 07/15

Улаанбаатар хот

### Ш.Пүрэвдоржийг ажилд томилох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, Авилгатай тэмцэх газрын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 05/ 5437 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын Сургалт судалгааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ширнэнгийн Пүрэвдоржийг 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ш.Пүрэвдоржийг 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 639.024 /зургаан зуун гучин есөн мянга хорин дөрвөн/ төгрөгөөр цалинжуулж, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийн хамт олгохыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Түр орлон гүйцэтгэгчийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн /Н.Одонтуяа/-д даалгасугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ